



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 1/25

Номгон

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр
2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгийг хангах хавсралтын 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардалд 4.0 (Дөрвөн сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642010061

Аймгийн Засаг даргын ...-ны өдрийн ... дугаар захирамжийн хавсралт



ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 10

Номгон

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнд	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4	5
Зорилт 1. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох				
1	Шадар сайдын Аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээрх ажил арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах	2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажил арга хэмжээний хэрэгжилтийг хувиар	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
2	Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газраас 2023 онд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллах	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2023 онд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжилтийн хувиар	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
3	Олон Улсын хэрэглэгчийн өдөр буюу 3 дугаар сарын 15-ны өдрийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан хэрэгжилтийн хувиар	3 сард	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
4	Зах зээлд бизнес эрхлэгчдийг шударгаар өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний зарчимд бүрэн нийцүүлэх, өрсөлдөөний соёл, ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн контент бэлтгэж түгээх	Контент бүтээж олон нийтэд түгээсэнээр	7 сард	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
5	Бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, үнийн хөөрөгдлийн эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлэх, аж ахуй эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх	Аж ахуй эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлсэн байна.	2 сард	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
6	Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн Хэрэглэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх	Хэрэглэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсэн тухай гомдол санал хүсэлтийг хуулийн хуагцаанд шийдвэрлэсэн байна.	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан

Зорилт 2. Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох				
7	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах идэвхтэн, сонгуультнуудад гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулах	Сургалтыг Монголын Хэрэглэгчийн Удирдлагын Академтай хамтран зохион байгуулна.	Жилдээ 1.0	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
8	Хүнсний аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хөрсөнд ургасан хүнсний ногооны ач холбогдолын талаар хэрэглэгчдэд гарын авлага эмхэтгэл бэлтгэн хүргэх	Хэрэглэгчдэд гарын авлага эмхэтгэл бэлтгэн хүргэх	Жилдээ 1.0	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
9	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд эрх зүйн боловсрол олгох аян зарлах, эрх зүйн сургалт зохион байгуулах	Сургалтыг хамтран зохион байгуулсан тоогоор	Жилдээ 1.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
10	Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах	Олон талт хэлбэрээр сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна	800.0	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
11	Хэрэглэгчийн эрх зүйн боловсролд туслах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийж, хэрэгжүүлэх	3 сард	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
Зорилт 3. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинд хяналт тавих				
12	Аймгийн төвийн хүнсний дэлгүүрүүдийн бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийж зөвлөмж өгөх.	Хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн байна	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
13	Хуванцар хог хаягдлаас ангижрах хөдөлгөөний аймгийн хэмжээнд өрнүүлэх "Соремо" үйлвэртэй хамтран ажиллах	Аяныг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
14	Аймгийн төвийн хүнсний үйлдвэрүүдэд бараа бүтээгдэхүүний хаяг шошгын бараа хадгалалт, хамгаалалтын байдалд эрүүл ахуй стандартад хяналт шалгалт хийж зөвлөмж өгөх.	Хяналт шалгалтыг 2 удаа хийгдсэн байна	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
15	Сумдын хүнсний дэлгүүр, зах худалдааны төвийн хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацаа, эрүүл ахуйд Хэрэглэгчдээс тандалтын судалгаа авах	Тандалт судалгааг 1 удаа хийнэ	2,8 сард	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг